



ДОРНОГОВЬ АЙМАГ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/60

Сайншанд сум

«Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын
ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.13, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Биеийн тамир, спортын газрын ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх, урамшуулах зорилгоор "Биеийн тамир, спортын газрын ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг ажилтан, албан хаагчдад танилцуулж, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг жил бүр батлуулан хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүний нөөц, дотоод хяналт хариуцсан ажилтан (Э.Оюунсүрэн)-д даалгасугай.



1000425

Биеийн тамир, спортын газрын даргын
2023 оны 10 сарын 20 ны өдрийн
.../60... дугаар тушаалын хавсралт



**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН
ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Биеийн тамир, спортын газрын хөдөлмөрийн дотоод журам болон төрийн албан хаагчтай холбоотой бусад дүрэм, журам нь энэхүү хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл болно.

1.2 Хэрэгцээ шаардлага:

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалтад төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, тэдгээрийн талаар төрийн байгууллагуудаас хэрэгжүүлэх бодлогыг уялдуулан зохицуулахаар заасан.

Энэхүү хөтөлбөр боловсруулагдан хэрэгжсэнээр Биеийн тамир, спортын газрын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдаж, ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгох, ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх үйл ажиллагааг өргөтгөх, гэр бүлийг дэмжих, ажлын нөхцөлийг сайжруулж таатай орчин бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Биеийн тамир, спортын газрын ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн асуудлыг бодит, үнэн зөв судалгаанд үндэслэн ээлттэй, ил тод шийдвэрлэх, албан хаагчдыг үр бүтээлтэй, идэвх, санаачилгатай, тогтвор суурьшилтай ажиллуулах үндсэн нөхцөл болох юм.

1.3. Хөтөлбөрийн хамрах хүрээ:

Энэхүү хөтөлбөрт Биеийн тамир, спортын газрын ажилтан, албан хаагчид хамрагдана.

Хоёр. Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим хугацаа, үе шат

2.1. Хөтөлбөрийн зарчим:

2.1.1 Төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомжийн хүрээнд ажиллах:

2.1.2 Ажилтан, албан хаагч нэг бүрийг хамруулах:

2.1.3 Ил тод, нээлттэй хэрэгжүүлэх:

2.1.4 Санхүүгийн болон бусад нөөц бололцоог бүрэн дайчлах:

2.1.5 Ажилтан, албан хаагчдын санаа бодолд тулгуурлан бодитой байх,

2.1.6 Шударга байх

2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат:

2.2.1 Биеийн тамир, спортын газрын ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2023-2027 онуудад хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт:

3.1 Зорилго:

3.1.1 Монгол Улсын Төрийн албаны тухай хууль дахь төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахтай холбогдсон заалтуудыг хэрэгжүүлэх, Биеийн тамир, спортын газрын ажилтан, албан хаагчдын үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах, албан тушаалын тодорхойлолтын дагуу эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

3.2 Зорилт:

3.2.1 Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох,

3.2.2 Төрийн албаны болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хангах арга замыг тодорхойлох.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах чиглэлээр:

4.1.1. Албан хаагчдыг чиглэл бүрээр мэргэшүүлэх, ажлын байранд суралцах, чадавхжуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах,

4.1.2. Албан хаагчидтай байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнууд ганцаарчлан болон хэсэгчилэн уулзах, хамт олны хурал, ярилцлагыг тодорхой сэдвийн хүрээнд зохион байгуулж хэвших,

4.1.3. Ажилтан, албан хаагчдын үйл ажиллагааг бодитой үнэлж, дүгнэх, төрийн дээд шагнал болон салбарын шагналд тодорхойлох, урамшуулах,

4.1.4. Интернет, дотоод сүлжээний байнгын тасралтгүй ажиллагааг хангах,

4.1.5. Шинээр ажилд томилогдсон ажилтныг хурдан хугацаанд дадлагажуулж мэргэшүүлж, төрийн албаны тасралтгүй байдлыг хангаж ажиллах,

4.1.6 Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг нарийвчлан гаргаж батлуулан ажлын ачааллыг тэнцвэржүүлэх:

4.1.7 Албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэлийг бодитой үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт боловсруулж батлуулан мөрдөх:

4.1.8. Засгийн газраас тогтоосон журмын дагуу үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох

4.1.9. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, ажилласан жилийг харгалзан зэрэг, дэв, ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг ил тод, шударгаар шийдвэрлэх,

4.2 Төрийн албан хаагчийн ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулах:

4.2.1 Ажилтан албан хаагчдын ажлын байрыг орчин үеийн оффисын стандартын жишигт нийжүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх,

4.2.2. Шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ээлж дараатай шинэчлэх, бичиг хэргийн хэрэгслийн хангалтыг тогтмол хийх,

4.2.3 Ажилтан, албан хаагчдын ажлын алжаал тайлах, түр амрах нөхцөлийг бүрдүүлэх,

4.2.4 Албан хаагчдыг албан ажлын зайлшгүй шаардлага, яаралтай ажлын үед аймгийн төвд унаагаар үйлчлэх,

4.2.5 Үйлчилгээний ажилтнуудыг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл болон үйлчилгээнд шаардагдах материалаар тасралтгүй хангах,

4.3. Албан хаагчдын амьдралын нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

Хөтөлбөрийн жилийн тайланг үнэлж, дүгнэсний үндсэн дээр дараа жилийн ажлаа тодорхой төлөвлөж, зохион байгуулна.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт:

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг байгууллагын жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

6.2. Албан хаагчдын сайн дурын үндсэн дээр хуримтлуулсан "Хамтын сан"-гийн хуримтлалаар зарим үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

6.3. Гадаадын байгууллагын төсөл хэрэгжүүлэх, хандивчлагчдын туслалцааг авах замаар санхүүжүүлж болно.

6.4. Байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэх боломжийг судална.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн:

7.1. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дор дурдсан үр дүнд хүрнэ.

- Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирч, тогтвор суурьшилтай ажиллах боломж бүрдэнэ.

- Албан хаагчид ажлын байранд тасралтгүй суралцсанаар мэргэшлийн ур чадвар тогтмол дээшилж, мэргэшсэн туршлагатай албан хаагчдаар хамт олон бүрдэнэ.

- Албан хаагчдын үр дүнтэй, бүтээмжтэй ажиллах нөхцөл, боломж бүрдэнэ.

- Албан хаагчдын нийгмийн баталгаа, төрийн албаны тасралтгүй тогтвортой байх зарчим хангагдана.

___оОо___